

ГОЛОМТ БАНК

**Хураангуй Санхүүгийн тайлангууд болон
Хараат бус аудиторын тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31

АГУУЛГА

Байгууллагын талаарх мэдээлэл

Удирдлагын хариуцлагын захидал

Хараат бус аудиторын тайлан

Хураангуй Санхүүгийн тайлангууд

Санхүүгийн байдлын тайлан 3

Орлого үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан 4

Хураангуй Санхүүгийн тайлангийн тодруулгууд

1 Бизнесийн үйл ажиллагаа 5

2 Хураангуй санхүүгийн тайлангууд 5

ГОЛОМТ БАНК ХК

Байгууллагын талаарх мэдээлэл

Үүсгэн байгуулах шийдвэр	Голомт Банк (цаашид “Банк” гэх) нь 1995 оны 03 дугаар сарын 06-ны өдөр анх үүсгэн байгуулагдсан.	
Гэрчилгээ ба Тусгай зөвшөөрөл	Банк нь 2023 оны 4 дугаар сарын 7-ны өдөр Монгол улсын Улсын бүртгэлийн ерөнхий газраас шинээр олгосон 2075377 тоот регистрийн дугаар бүхий 9007001012 тоот Улсын Бүртгэлийн гэрчилгээг эзэмшдэг. Банк нь 1995 оны 3 дугаар сарын 6-ны өдөр банкны үйл ажиллагаа эрхлэх 25 тоот Тусгай зөвшөөрлийг Монголбанкнаас авсан.	
Төлөөлөн Удирдах Зөвлөл	Ч.Мөнхцэцэг Урс Е.Шварценбах Д.Мөнхтөр Л.Болормаа О.Ганжолоо Ж.Үнэнбат Лопез Абелло Жэймс Б.Двайер Александр Пикер Роберт В.Ван Свитен	<i>ТУЗ-ийн дарга</i> <i>ТУЗ-ийн гишүүн</i> <i>ТУЗ-ийн гишүүн</i> <i>ТУЗ-ийн гишүүн</i> <i>ТУЗ-ийн гишүүн</i> <i>ТУЗ-ийн гишүүн</i> <i>Хараат бус гишүүн</i> <i>Хараат бус гишүүн</i> <i>Хараат бус гишүүн</i> <i>Хараат бус гишүүн</i>
Гүйцэтгэх Удирдлага	К.Норихико Г.Ганболд А.Одонбаатар М.Сайнбилэг С.Мөнхтуяа М.Наранхүү Т.Отгон Б.Содболор Ц.Байгалмаа Н.Очирхуяг Г.Уянга Б.Сугар-Эрдэнэ А.Ганчимэг Ё.Пүрэвбат Б.Энхзаяа Х.Пүрэвдорж О.Батцэнгэл А.Нямсүрэн	<i>Гүйцэтгэх захирал</i> <i>Ерөнхийлөгч</i> <i>Гүйцэтгэх захирлын орлогч</i> <i>Мэдээлэл технологи хариуцсан захирал</i> <i>Санхүүгийн удирдлагын газрын захирал</i> <i>Зээлийн газрын захирал</i> <i>Эрсдэлийн удирдлагын газрын захирал</i> <i>Нөөцийн удирдлагын газрын захирал</i> <i>Иргэдийн банкны газрын захирал</i> <i>Маркетинг, олон нийттэй харилцах газрын захирал</i> <i>Хүний нөөцийн удирдлагын газрын захирал</i> <i>Байгууллагын банкны газрын захирал</i> <i>Байгууллага хөгжлийн газрын захирал</i> <i>Бүртгэл тооцооны газрын захирал</i> <i>Олон улсын банкны газрын захирал</i> <i>Захиргааны газрын захирал</i> <i>Мэдээлэл технологийн газрын захирал</i> <i>Бизнес процесс менежментийн газрын захирал</i>
Хаяг	Голомт Банкны төв байр Сүхбаатарын талбай 5, Ш/Х-22 Улаанбаатар 15160, Монгол улс	
Аудитор	Кэй Пи Эм Жи Аудит ХХК Блю Скай Тауэр, 6 давхар, 602 тоот Энхтайваны өргөн чөлөө 17, Сүхбаатар дүүрэг 1-р хороо Улаанбаатар хот 14240, Монгол Улс	

ГОЛОМТ БАНК ХК

Удирдлагын хариуцлагын захидал

Голомт Банк ХК (цаашид "Банк" гэх)-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ч.Мөнхцэцэг, Гүйцэтгэх захирал К.Норихико болон Санхүүгийн Удирдлагын Газрын захирал С.Мөнхтуяа бид энд хавсаргасан хураангуй санхүүгийн тайлан нь Банкны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүнг Тодруулга 2-т дурдсан үндэслэлийн дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн болохыг батламжилж байна.

Банкны удирдлагаас 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн хураангуй санхүүгийн тайланг шийдвэрийн дагуу зөвшөөрч батлав.



К.НОРИХИКО

Гүйцэтгэх захирал

С.МӨНХТУЯА

Санхүүгийн Удирдлагын
Газрын захирал

Улаанбаатар,

Монгол Улс

Огноо: 2024 оны 3 дугаар сарын 27



Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар-14240,
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Энхтайваны өргөн чөлөө 17,
Блю Скай Тауэр, 602 тоот

Утас : +976 7011 8101
Факс: +976 7011 8102
www.kpmg.com/mn

Хураангуй Санхүүгийн Тайлангийн Хараат Бүс Аудиторын Тайлан

Голомт Банк Хувьцаат Компанийн Хувьцаа Эзэмшигчид болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд:

Дүгнэлт

Хураангуй санхүүгийн тайлан нь Голомт Банк ХК (цаашид “Банк” гэх)-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн бэлтгэсэн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх хураангуй санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн хураангуй ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан болон холбогдох тодруулгаас бүрдсэн.

Бидний дүгнэлтээр, Банкны хавсаргасан хураангуй санхүүгийн тайлан нь Тодруулга 2-д дурдсан үндэслэлийн дагуу бүх материаллаг зүйлсийн хувьд аудитлагдсан санхүүгийн тайлантай нийцэж байна.

Хураангуй санхүүгийн тайлан

Хураангуй санхүүгийн тайлан нь СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудад шаардсан бүх тодруулгуудыг агуулаагүй болно. Иймд энэхүү хураангуй санхүүгийн тайлан болон аудитын тайлан нь аудитлагдсан санхүүгийн тайлан болон аудитын тайланг орлох үндэслэл болохгүй.

Аудитлагдсан санхүүгийн тайлан болон аудитын тайлан


Бид 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн аудитын тайлангаараа тухайн аудитлагдсан санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт өгсөн. Уг тайланд аудитын гол онцлох зүйлсийн талаарх мэдээллийг тусгасан. Аудитын гол онцлох зүйлс гэдэг нь бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал ач холбогдол бүхий зүйлс юм.

Удирдлагын хураангуй санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага


Тодруулга 2-д дурдсан үндэслэлийн дагуу хураангуй санхүүгийн тайланг бэлтгэх нь Банкны удирдлагын хариуцлага болно.

Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Хураангуй санхүүгийн тайлан нь бүх материаллаг зүйлсийн хувьд аудитлагдсан санхүүгийн тайлантай нийцэж байгаа эсэхийг шалгах Аудитын Олон Улсын Стандарт (“АОУС”) 810 буюу “Хураангуй санхүүгийн тайланд дүгнэлт өгөх гэрээт ажил”-аар шаардсан горимуудыг гүйцэтгэж, түүндээ үндэслэн бидний дүгнэлтийг агуулж буй аудитын тайланг танилцуулах нь бидний үүрэг хариуцлага юм.



Кэй Пи Эм Жи Аудит ХХК
2024 оны 3 дугаар сарын 27-ны өдөр
Монгол Улс, Улаанбаатар хот

Баталгаажуулсан:


Г. Соёлмаа
Ерөнхий Захирал



Баталсан:


Гун Пён Шиг
Партнер

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Тиймээс аудитын тайланг хэрэглэгчид нь уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүйг анхаарна үү. Энэхүү тайлан нь зөвхөн Банкны хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.

Голомт Банк ХК
Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр

2023 оны 12 сарын 31 2022 оны 12 сарын 31

Хөрөнгө

Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө	1,717,584,758	1,142,404,090
Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц	468,929,955	357,581,959
Урвуу репо хэлцэл	646,835,976	-
Бусад банкуудад байршуулсан хөрөнгө	1,403,654,333	1,566,963,380
Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт	1,733,092,620	1,230,251,009
Өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт	24,082,823	22,513,491
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	4,712,108,705	3,697,633,345
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	29,101,738	6,687,575
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	6,586,475	10,276,475
Бусад хөрөнгө	489,826,692	283,402,128
Хойшлогдсон татварын хөрөнгө	6,916,322	-
Үүсмэл санхүүгийн хөрөнгө	202,386,920	436,146,109
Биет бус хөрөнгө	18,878,648	20,948,388
Үндсэн хөрөнгө	151,082,991	151,367,641
Ашиглах эрхтэй хөрөнгө	16,775,279	15,192,622
Өмчлөх бусад хөрөнгө	-	43,191,321

Нийт Хөрөнгө **11,627,844,235** **8,984,559,533**

Өр төлбөр

Бусад банкуудын байршуулсан хөрөнгө	130,991,856	52,394,763
Харилцагчдын харилцах, хадгаламж	8,036,633,655	5,743,297,867
Бусад зээлийн эх үүсвэр	1,410,928,722	1,916,312,092
Репо хэлцэл	711,674,163	211,347,644
Орлогын татварын өглөг	42,008,579	30,961,395
Хойшлогдсон татварын өр төлбөр	-	20,743,288
Үүсмэл санхүүгийн өр төлбөр	2,890,938	-
Түрээсийн өр төлбөр	17,390,429	16,290,486
Бусад өр төлбөр	204,235,171	131,306,235

Нийт өр төлбөр **10,556,753,513** **8,122,653,770**

Эзэмшигчдийн өмч

Хувь нийлүүлсэн хөрөнгө	202,164,327	202,164,327
Нэмэгдэж төлөгдсөн капитал	301,481,120	301,481,120
Хуримтлагдсан ашиг	460,718,070	283,420,821
Бусад нөөц	106,727,205	74,839,495

Нийт эзэмшигчдийн өмч **1,071,090,722** **861,905,763**

Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч **11,627,844,235** **8,984,559,533**

2024 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Банкны удирдлагыг төлөөлж энэхүү тайланг нийтлэхийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурав.



К.НОРИХИКО
Гүйцэтгэх захирал

С.МӨНХТУЯА
Санхүүгийн Удирдлагын Газрын
захирал

Голомт Банк ХК

Орлого үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

<i>Мянган төгрөгөөр</i>	2023	2022
Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого	792,710,179	576,384,931
Бусад адилтгах орлого	48,022,376	33,524,234
Хүүгийн зардал	(361,580,996)	(222,857,161)
Бусад адилтгах зардал	(1,859,443)	(1,481,221)
Хүүгийн цэвэр орлого	477,292,116	385,570,783
Хүлээгдэж буй зээлийн алдагдлын сангийн буцаалт/(зардал)	28,074,700	(45,969,488)
Хүлээгдэж буй зээлийн алдагдлын сангийн буцаалт/(зардал)-ын дараах хүүгийн цэвэр орлого	505,366,816	339,601,295
Хураамж, шимтгэлийн орлого	102,170,890	84,131,978
Хураамж, шимтгэлийн зардал	(60,190,417)	(39,961,185)
Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс үүссэн олз	3,439,577	7,326,760
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх бусад зээлийн эх үүсвэрийн гэрээний өөрчлөлтөөс үүссэн олз	-	1,794,198
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгийн борлуулалтаас үүссэн гарз	(641,141)	(48,339)
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс үүссэн (гарз)/олз	(133,811,366)	34,725,648
Үнэт металлын арилжаанаас үүссэн олз	9,362,739	7,815,364
Гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн гарз	(8,254,552)	(10,060,088)
Гадаад валютын арилжаанаас үүссэн олз	62,258,414	58,228,967
Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх зээлийн бодит үнэ цэнийн гарз	(805,488)	(6,120,026)
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгүүдийн өөрчлөлтөөс үүссэн үнэ цэнийн олз/(гарз), бүртгэлээс хасагдахгүй	1,321,865	(1,688,544)
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын эрсдэлийн алдагдлын сангийн буцаалт	61,009	4,181
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын эрсдэлийн сангийн зардал	(2,540,274)	(662,324)
Бусад банкуудад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сангийн буцаалт /(зардал)	1,407,047	(3,584,406)
Зах зээлийн хүүгээс бага хүүтэй олгосон санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн гарз	(2,206)	(235,786)
Бусад хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал	(1,557,516)	(868,016)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн (гарз)/олз	(12,248,114)	5,413
Өмчлөх бусад хөрөнгийн бодит үнэ цэнийн бууралтын сангийн зардал болон эрсдэлийн сангийн зардал	-	(96,897,798)
Аккредитив, баталгааны эрсдэлийн сангийн зардал	(1,266,673)	(509,336)
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний өөрчлөлтийн гарз	-	(3,372,606)
Ногдол ашгийн орлого	75,636	32,813
Үйл ажиллагааны бусад орлого	2,288,280	1,154,973
Удирдлагын болон үйл ажиллагааны бусад зардал	(200,159,282)	(175,345,911)
Бусад гарз, цэвэр дүнгээр	(240,148)	(1,669,241)
Татварын өмнөх ашиг	266,035,096	193,797,984
Орлогын албан татварын зардал	(56,864,051)	(77,295,936)
Тайлант жилийн ашиг	209,171,045	116,502,048
Бусад дэлгэрэнгүй орлого/(алдагдал):		
<i>Ирээдүйд ашиг, алдагдалд ангилагдах зүйлс:</i>		
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөгдөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт		
- Тайлант жилийн олз/(гарз)	53,714,970	(50,471,551)
- Худалдан борлуулснаас ашиг, алдагдалд дахин ангилагдсан олз	641,141	48,339
Бусад дэлгэрэнгүй орлогын тайланд шууд бүртгэсэн орлогын татвар	(13,589,028)	12,605,803
<i>Ирээдүйд ашиг, алдагдалд ангилагдахгүй зүйлс:</i>		
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтаас үүссэн гарз	-	(558,251)
Бусад дэлгэрэнгүй орлогын тайланд шууд бүртгэсэн орлогын татвар	-	139,563
Бусад дэлгэрэнгүй орлого/(алдагдал)	40,767,083	(38,236,097)
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого	249,938,128	78,265,951
Банкны эзэмшигчдэд хамаарах нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг	258.66	163.80
Банкны эзэмшигчдэд хамаарах нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг	258.61	163.73

1 Бизнесийн үйл ажиллагаа

Голомт Банк ХК ("Банк") нь Монгол Улсын хууль, эрх зүйн хүрээнд үүсгэн байгуулагдсан. Банк нь Монголын Улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компани юм. 2023 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Банкныг шууд хянадаг, эцсийн шатны толгой компани нь Голомт Файнэншил Групп ХХК байна. Голомт Файнэншил Групп ХХК-ийн эзэмшигч Д.Баясгалан нь 2023 оны 12 сарын 31 болон 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Голомт Банкны эцсийн өмчлөгч юм.

Банк нь 2023 оны 4 дугаар сарын 07-ны өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас 2075377 регистрийн дугаар бүхий 9007001012 тоот Улсын Бүртгэлийн гэрчилгээг шинэчлэн авсан. Банк нь Монгол улсын төв банк болох Монголбанкнаас 1995 оны 3 сарын 06-нд олгосон 25 дугаартай банкны үйл ажиллагаа явуулах бүрэн зөвшөөрөлтэй.

Банкны хүчин төгөлдөр дүрмийн дагуу Банкны эрхлэх үндсэн үйл ажиллагаа нь:

- Хадгаламж;
- Зээлийн үйлчилгээ;
- Картын үйлчилгээ;
- Баталгаа ба аккредитив;
- Мөнгөн шилжүүлэг;
- Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, болон арилжаалах;
- Үнэт металл худалдах, худалдан авах, хадгалах, болон арилжаалах;
- Гадаад төлбөр тооцоо;
- Үнэт цаас гаргах, арилжаалах;
- Санхүүгийн түрээсийн үйлчилгээ;
- Зээл болон бусад санхүүгийн хэрэглүүр худалдан авах, худалдах;
- Кастодиан банкны үйлчилгээ;
- Хууль эрх зүйн хүрээнд хязгаарлагдаагүй бусад санхүүгийн үйлчилгээ болон Монголбанк ба Засгийн Газрын бусад байгууллагуудын хүлээн зөвшөөрсөн бусад үйлчилгээг үзүүлнэ.

2 Хураангуй санхүүгийн тайлан

Хураангуй санхүүгийн тайланг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу бэлтгэгдсэн аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн бэлтгэсэн.

Энэхүү хураангуй санхүүгийн тайланг бэлтгэхдээ уг тайланд толилуулах шаардлагатай мэдээллийг үнэн зөв тодорхойлохыг удирдлагаас шаарддаг бөгөөд эдгээр мэдээлэл нь бүх материаллаг зүйлсийн хувьд аудитлагдсан санхүүгийн тайлантай нийцсэн байна.

Удирдлага хураангуй санхүүгийн тайланг бэлтгэхдээ дараах шалгууруудыг харгалзаж үзсэн:

- а) Хураангуй санхүүгийн тайланд тусгагдсан мэдээлэл нь бүрэн хэмжээний аудитлагдсан санхүүгийн тайлангийн холбогдох мэдээлэлтэй нийцэж байгаа эсэх; болон
- б) Хураангуй санхүүгийн тайлан, түүний тодруулгууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд бүрэн хэмжээний аудитлагдсан санхүүгийн тайланд тусгагдсан мэдээллийг мушгин гуйвуулах, төөрөгдүүлэхээс зайлсхийсэн шаардлагатай мэдээллийг агуулсан эсэх;
- в) Банкны тухай Монгол Улсын хуулийн дагуу аудитлагдсан жилийн санхүүгийн тайланг нийтэд хэвлэлээр мэдээлэх шаардлага зэргийг авч үзсэн.

Удирдлага нь Банкны тухай хууль, дүрэм журмын нийцлийг хангах зорилгоор өмчийн өөрчлөлтийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайлангууд нь нэмэлт шаардлагатай мэдээллээр хангахгүй тул тэдгээрийг хураангуй санхүүгийн тайланд оруулаагүй болно.

Голомт Банк ХК-ийн бүрэн хэмжээний аудитлагдсан санхүүгийн тайлантай танилцахыг хүсвэл Банкинд хүсэлт гарган танилцах боломжтой.